



РЕЛАЭС
СЕКЮРИТИЗ
АУДИТ

АУДИТЫН ДҮГНЭЛТ

МЕРЕКС ХК ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн дүгнэлттэй холбоотой дүгнэлт, удирдлагад илгээх захидал, хувьцаа эзэмшигчдийн тархалтын мэдээ, санхүүгийн тайлан /сангийн яамны сайтаас татсан/ хяналтын тооллогын материал, ТУЗ-ын шийдвэрүүд, татварын тодорхойлолт зэрэг материал

Хуудасны тоо (01-057)

Уаанбаатар хот

2021 он

RSA

"РЕЛАЗНС СЕКЮРИТИЗ
АУДИТ" ХХК

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг
9-р хороо Компьютер молл 7024 тоот
Утас: 99813174
E-mail: rsamongolia@gmail.com

2021-06-30 № 03/041
Танай _____-ны № _____-т

МЕРЕКС ХК –ны хувьцаа

Эзэмшигч нарт

Аудиторын зөвлөмж
хүргүүлэх тухай

Бид танай Мерекс ХК-ны 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж өгнө үү гэсэн 2021 оны 06 дугаар сарын 14 ний өдрийн 01 тоот хүсэлтийг хүлээн авч 2020 оны санхүүгийн тайланг хянаж бодит байдал болон зөвлөмжийг хүргүүлж байна. Хүлээн авна уу.

Жич: Хэрэв 2020 оны санхүүгийн тайлангаа засварлах бол засварлах хуулийн хугацаа 2021 оны 12-дугаар сарын 31-нд дуусах тул энэ хугацаанд багтааж нягтлан бодогч нарын ажлыг албан ёсоор хүлээлцүүлж, санхүүгийн тайлангаа засварлаж болно. Хамтарч ажилласанд баярлалаа

Захирал



Ж.Цэцэгмаа

РЕЛАЗНС
СЕКЮРИТИЗ АУДИТ ХХК

Page: 01

RSA

"РЕЛАЗНС СЕКЮРИТИЗ
АУДИТ" ХХК

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг
9-р хороо Компьютер молл 7024 тоот
Утас: 99813174
E-mail: rsamongolia@gmail.com

2021-06-30 № 024/071
Танай _____-ны № _____-т

"МЕРЕКС" ХК-ийн

Хувьцаа эзэмшигч нарт

Хараат бус Аудиторын

Меркес ХК-ны ТУЗ болон

гүйцэтгэх удирдлагад илгээх захидал

"МЕРЕКС" ХК-ийн 2020 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлан тэнцэл, санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийж гүйцэтгэлээ

Бидний дүгнэлтээр "МЕРЕКС" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх баланс, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу илэрхийлэгдсэн гэх үндэслэл байхгүй байна. Тус компаний 2020 оны санхүүгийн тайланд компаний удирдлага, санхүүгийн ажилтан нар ажлаасаа чөлөөлөгдөөд явахдаа ажлаа албан ёсоор хүлээлцээгүй, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл огт байхгүй учир материаллаг эрсдэлтэй гэж үзэн дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

Хувьцаа эзэмшигчид болон удирдах зөвлөлд доорхи дүгнэлтийг хүргэж байна. Үүнд:

1. 2020 оны санхүүгийн жилийн эцсийн тайлангаар гарсан бэлэн мөнгө болон харилцах дансны үлдэгдэл 4,415,539 төгрөгний үлдэгдэл кассын тайлан болон харилцах дансны хуулга байхгүй учир үлдэгдэл нь нотлогдохгүй байна.

2. 2020 оны санхүүгийн жилийн эцэст тооллого хийж тооцоо бодсон ямар ч баримт байхгүй, 2021 оны 1 улиралд үйл ажиллагаа явуулаагүй гэсэн боловч ТУЗ хүлээн авахад 779,248,065 төгрөгний түүхий эд материалын үлдэгдэл байхгүй байсан байна. /Тухайн үед ажиллаж байсан ажилчдын тодорхойлолтыг үндэслэв/

RSA

"РЕЛАЗНС СЕКЮРИТИЗ
АУДИТ" ХХК

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг
9-р хороо Компьютер молл 7024 тоот
Утас: 99813174
E-mail: rsamongolia@gmail.com

2021-06-30 № 02/041
Танай _____-ны № _____-т

"МЕРЕКС" ХК-ийн

Хувьцаа эзэмшигч парт

Хараат бус Аудиторын

Меркес ХК-ны ТУЗ болон

гүйцэтгэх удирдлагад илгээх захидал

"МЕРЕКС" ХК-ийн 2020 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлан тэнцэл, санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийж гүйцэтгэлээ

Бидний дүгнэлтээр "МЕРЕКС" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх баланс, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу илэрхийлэгдсэн гэх үндэслэл байхгүй байна. Тус компаний 2020 оны санхүүгийн тайланд компаний удирдлага, санхүүгийн ажилтан нар ажлаасаа чөлөөлөгдөөд явахдаа ажлаа албан ёсоор хүлээлцээгүй, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл огт байхгүй учир материаллаг эрсдэлтэй гэж үзэн дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

Хувьцаа эзэмшигчид болон удирдах зөвлөлд доорхи дүгнэлтийг хүргэж байна. Үүнд:

1. 2020 оны санхүүгийн жилийн эцсийн тайлангаар гарсан бэлэн мөнгө болон харилцах дансны үлдэгдэл 4,415,539 төгрөгний үлдэгдэл кассын тайлан болон харилцах дансны хуулга байхгүй учир үлдэгдэл нь нотлогдохгүй байна.

2. 2020 оны санхүүгийн жилийн эцэст тооллого хийж тооцоо бодсон ямар ч баримт байхгүй, 2021 оны 1 улиралд үйл ажиллагаа явуулаагүй гэсэн боловч ТУЗ хүлээн авахад 779,248,065 төгрөгний түүхий эд материалын үлдэгдэл байхгүй байсан байна. /Тухайн үед ажиллаж байсан ажилчдын тодорхойлолтыг үндэслэв/

3. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө 449,013,454 төгрөгний үлдэгдэлтэй гэж санхүүгийн тайланд тусгасан боловч бас ямар хөрөнгө гэдэг нь мэдэгдэхгүй бүртгэл байхгүй байлаа.

Эдгээр зөрчлүүд нь Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2-ын 1-т /Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, өр төлбөр, тооцооны тооллогыг заавал хийнэ/ гэсэн заалт зөрчсөн.

Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 2-ын 6-т Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх ,үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж ,үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах/ гэж заасан байдаг тул энэ заалт хэрэгжээгүй байна.

4. 2020 оны санхүүгийн жилийн эцсийн тайлангаар гарсан авлага өглөгийн түүх нягтлан бодох бүртгэлийн холбогдох журнал байхгүй учир хэдийд юуны учир үүссэн өр авлага болох нь тодорхойгүй, Тооцоо нийлэлт хийгдээгүй, баримт нотолгоо байхгүй байна. Үүнд дансны авлага 1,510,172,347 төгрөг, бусад авлага 70,450,490 төгрөг байна.

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Өглөг дансны үлдэгдэл 1,619,594,128 төгрөг байна.

Өглөг, авлагатай холбоотой зөрчлүүд нь Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-ын 5-т Байгууллагын гүйцэтгэх удирдлага ,нягтлан бодогч нь /Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянаж баталгаажуулах/ үүрэгтэй гэсэн заалт хэрэгжээгүйтэй холбоотой байна.

5. 2020 оны санхүүгийн жилийн эцсийн тайлангаар Урьдчилж гарсан зардал дансанд 85,411,000 төгрөг байгаа бөгөөд энэхүү урьдчилж гарсан зардал 2019 2020 онуудад үргэлжлэн урьдчилж гарсан зардал дансанд үлдэгдэл болоод явж байна. Бас ямар зардал ве гэдэг нь тодорхойгүй, ямар ч нотлох баримт байхгүй.

6. Төсвийн өмнө хүлээсэн үүрэг хангалтгүй. 2020 оны санхүүгийн жилийн эцсийн тайлангаар татварт 656,049,278 төгрөг, нийгмийн даатгалд 236,711,638 төгрөг нийт улсын төсөвт 892,760,916 төгрөгний өртэй .

7. 2020 оны санхүүгийн жилийн эцсийн тайлангаар Алдагдал 1,777,583,054 төгрөг байна.

Дээрхи бүх зөрчил дутагдал нь Мерекс ХК-ны гүйцэтгэх засаглал шаардлагын хэмжээнд идэвхитэй ажиллаж чадаагүйгээс үүссэн гэж үзлээ.

Дүгнэлтийн үндэслэл:

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компаний тухай хуулиудыг үндэслэн гаргалаа.

Хамтарч ажилласанд баярлалаа

ЗАХИРАЛ



Ж.ЦЭЦЭГМАА

Хараат бус Аудиторын дүгнэлт

МЕРЕКС" ХК-ийн 2020 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлан тэнцэл, санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийж гүйцэтгэлээ

Бидний дүгнэлтээр "МЕРЕКС" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх баланс, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу илэрхийлэгдсэн гэх үндэслэл байхгүй байна. Тус компаний 2020 оны санхүүгийн тайланд компаний удирдлага, санхүүгийн ажилтан нар ажлаасаа чөлөөлөгдөөд явахдаа ажлаа албан ёсоор хүлээлцээгүй, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл огт байхгүй учир материаллаг эрсдэлтэй гэж үзэн дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

Дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах явдал юм.

Аудитын гол асуудлууд:

Бид аудитын нягтлах ажлыг хийх явцдаа доорхи АОУС-уудыг мөрдөн ажиллалаа.

Үүнд: АОУС500, АОУС510, АОУС530, АОУС315, АОУС250, АОУС260, АОУС230

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС –ын дагуу бэлтгэх толилуулах нь компаний удирдлагын хариуцлага байна. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

ЗАХИРАЛ



Ж.Цэцэгмаа

АУДИТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭСЭН ГОРИМ ЗӨВЛӨМЖ:

Байгууллагын нэр, тайлант хугацаа: "МЕРЕКС" ХК, 2021 он

Үзүүлэлт

Гүйцэтгэсэн горим, санал

Гүйцэтгэсэн горим

- НББ-ийн бодлогын баримт бичигтэй эсэх, түүний хэрэгжилт, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өглөг, Дансны авлага, хуримтлагдсан ашиг, орлого, мөн зардлын дансуудын журналын бичилт, ерөнхий журнал зэргийг санхүүгийн аудит хийхээр шаардахад шинэ нягтлан бодогчид огт ямар ч баримт материалыг хүлээлгэж өгөөгүй буюу нягтлан бодогчийн ажлыг хүлээлцүүлээгүй байна
- санхүүгийн тайлан дахь холбогдох дансны дүнтэй тулгах, зарим материаллаг дүнтэй үлдэгдлийн хувьд тулган баталгаажуулалт хийх зорилгоор АОУС 260, АОУС 240, АОУС 500, АОУС 501, АОУС 510 ын дагуу хөрөнгийн тооллого хийх, асууж тодруулах, давтан тооцоолол хийх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Цаашид анхаарах асуудал:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын Баримт бичигийг шинэчилэн боловсруулах шаардлагатай Учир нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг огт байхгүй байна.
- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэлийг одоо дахин хянаж үзээд холбогдох зардлын болон хөрөнгийн дансанд бичих
- Авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдлийг холбогдох байгууллага, хувь хүнтэй тооцоо нийлж өрийг барагдуулах ажлыг зохион байгуулах.
- Бүх гишүүдийн хурлыг хугацаанд нь зохих хууль журмын дагуу хийж хэвших
- Өртгийн тооцооллыг үнэн зөв хийх

Аудиторын санал, зөвлөмж

- НББ-ийн бодлогын баримт бичиг гэдэг нь компанийн санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой, урт хугацаанд, эрсдэл багатайгаар, үр дүнтэйгээр удирдан зохион байгуулахад чиглэсэн компанийн бодлогын нэг хэсэг юм. НББ-ийн бодлогын баримт бичиг нь компанийн бүх л хугацааны зорилго, чиглэлд нийцсэн стандарт баримт бичиг байх бөгөөд түүний дагуу санхүүгийн үйл ажиллагаа явагдаж байх ёстой. Үйлчлүүлэгчийн хувьд энэхүү баримт бичгийг шинэчилэн боловсруулах шаардлагатай байгаа нь НББ-ийн энгийн бөгөөд нарийн төвөгтэй үйл ажиллагаа, тооцооллыг хэрхэн тооцож, бүртгэж, тайлагнах нь ойлгомжгүй, санхүүгийн бүртгэлийн алдааны эрсдлийг дагуулж байдаг. Иймд НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулах ажилд компанийн удирдлагын зүгээс анхаарал хандуулж удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг зөвлөж байна. НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулах ажилд удирдах болон үйлдвэрлэл хариуцсан ажилтангууд бүгд оролцоно.
- 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд цаашид анхаарах асуудалд дурьдагдсан дансанд үлдэгдлээр байгаа боловч бодитоор байхгүй байгаа түүхий эд бараа материал, эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгүүд, мөн өр, авлагуудыг тооцоо нийлж цаашид хэрхэхийг шийдэх
- Үндсэн хөрөнгө болон түүхий эд материал, сэлбэг хэрэгслэл, ажилтан албан хаагчдын хэрэглэж байгаа эд хогшлын тооллогыг зохих хууль журмын дагуу хийж, эд хариуцагч нарын тооцоо бодож хэвших.
- Мөнгөн касс болон харилцахын дансны үлдэгдлийн баталгаа, кассын тайлан гаргаж журналын

бичилтийг цаг тухайд нь хийж, мөнгөн орлого зарлагын гүйлгээг холбогдох хууль журмын дагуу нягтлан бодох бүртгэлд хөтлөж хэвших

- Урьдчилж гарсан зардал дансанд олон жил дамнасан тооцоонуудыг хэзээ хэрхэн үүссэнийг судлаж холбогдох зардлын болон хөрөнгийн дансанд эсвэл авлага болон бусад холбогдох дансанд бичих
- Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн тооллогыг хийж, зохих хууль дүрмийн дагуу нягтлан бодох бүртгэлд бичих
- Бусад эргэлтийн бус хөрөнгө дансны үлдэгдлийг нягтлан шалгаж бүртгэж байх.
- Татвар болон НДШ зэргийг хуулийн дагуу ногдуулж цаг хугацаанд нь төлж хэвшин төсвийн сахилга батыг хангаж ажиллах

Аудитын шалгалтын ажлын тайлан бэлтгэсэн: "Релазнс секюритиз аудит" ХХК

